



## “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр /цаашид “Хөтөлбөр” гэх/-ийн зорилго нь компанийн дотоод мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журам зааврыг “Компанийн засаглалын кодекс”-ийн зарчимд нийцүүлэн баталгаажуулах, дагаж мөрдсөнөөр компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэвшил болгоход оршино.

Хоёр. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1 Хөтөлбөрийн зорилт:

- 2.1.1 Хувьцаа эзэмшигчдийн эрхийг баталгаажуулах
- 2.1.2 Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/ болон гүйцэтгэх удирдлагын хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх
- 2.1.3 Тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах
- 2.1.4 Эрсдэлийн удирдлагыг сайжруулах
- 2.1.5 Хяналтын тогтолцоог сайжруулах
- 2.2 Хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
  - 2.2.1 Компанийн тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, “Компанийн засаглалын кодекс”-т тусгагдсан бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг компанийн засаглалын үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн мөрдөх
  - 2.2.2 Компанийн бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд комплайнсын хяналтыг тогтмол хэрэгжүүлэх
  - 2.2.3 Эрх бүхий албан тушаалтан, ажилтныг компанийн засаглалын сургалтанд хамруулах
  - 2.2.4 Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэр

Гурав. Хөтөлбөрийн зохион байгуулалт

- 2.1 Энэхүү хөтөлбөрийг компанийн ТУЗ нь өөрийн байгууллагын бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц зохион байгуулалтанд нийцүүлэн баталж, холбогдох бодлогын баримт бичиг, дүрэм, журам зааврын хэрэгжилтэд хяналт тавина.
- 2.2 ТУЗ нь дараах чиглэлээр бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг шинэчлэх буюу шинээр баталж мөрдөнө. Үүнд:
  - 3.2.1 Дүрэм, бодлогын баримт бичиг, заавар болон бусад

Заалт	Бодлогын баримт бичгийн нэр
3.2.1.1.	Компанийн ёс зүйн дүрэм
3.2.1.2.	Компанийн залгамж халааны бодлого
3.2.1.3.	Компанийн цалин урамшууллын бодлого
3.2.1.4.	Компанийн ногдол ашгийн бодлого
3.2.1.5.	Компанийн эрсдэлийн удирдлагын заавар
3.2.1.6.	Компанийн дотоод аудитын заавар
3.2.1.7.	Компанийн дотоод хяналтын заавар
3.2.1.8.	Компанийн комплайнсын хяналтын заавар

### 3.2.2 Дотоод журам:

Заалт	Дотоод журмын нэр
3.2.2.1.	Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын журам
3.2.2.2.	Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
3.2.2.3.	Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам
3.2.2.4.	Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам
3.2.2.5.	Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам
3.2.2.6.	Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааны журам
3.2.2.7.	Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам
3.2.2.8.	Компанийн мэдээллийн ил тод байдлын журам

#### Дөрөв. Тайлагнал, үнэлгээ

- 4.1 ТУЗ нь байгууллагын дүрэм, бодлогын баримт бичиг, заавар журам, загварыг боловсруулах мөрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, явцын талаар жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнана.
- 4.2 ТУЗ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, компанийн засаглалын үнэлгээг компанийн үйл ажиллагааны тайланд тусгаж, компанийн цахим хуудсанд байршуулна.
- 4.3 ТУЗ нь жил бүрийн эхний улиралд багтааж, компанийн засаглалыг үнэлэх асуулгын дагуу өөрийн компанийн засаглалын түвшинг үнэлж болно.
- 4.4 ТУЗ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай хамт Хороонд хүргүүлнэ.

#### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хугацаа	Тайлагнал, үнэлгээ
2011	
2012	
2013	
2014	
2015	
2016	
2017	
2018	
2019	
2020	
2021	